



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/БС

Мандалговь

**Б.Уранжаргалыг Сайнцагаан сумын Засаг даргын  
Тамгын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн  
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Баярсайхан овогтой Уранжаргал 52.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Уранжаргалын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь  
салбар зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын  
24-ны өдрийн 17 дугаар тогтоолын хавсралт



**Сайнцагаан сумын ЗДТГ-ын төсвийн ерөнхий  
нягтлан бодогчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Б.Уранжаргалын тухай дүгнэлт**

1. Б.Уранжаргал нь 1994 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 29 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2012-2019 онд Санхүү эдийн засгийн их сургуулийг нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.
3. Б.Уранжаргалын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Сайнцагаан сумын ЗДТГ-ын төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ